

**Дархан-Уул аймаг дахь газар өмчлөл, эзэмшил,
ашиглалтын байдал, хуулийн хэрэгжилт**



**Газар олголтын үйл ажиллагааг олон нийтэд ил
тод, нээлттэй мэдээлэх шаардлагатай байна**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Нийцлийн аудитын газар

Аудитын менежер
Б.Алтанзул

Туслах аудитор
Л.Нямтөмөр

2013 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Вэб
сайтаас үзнэ үү.

www.mnao.mn

Аудитын тайлан
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 261740,
260949 дугаарын утас,
факсаар харилцана уу.

Хаяг

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага
тойруу-3
Засгийн газрын IY байр
Улаанбаатар хот 15160
Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт

Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан
хүрээ, арга зүй 3

Аудитад ашигласан хууль тогтоомж,
шалгуур үзүүлэлт 3

Үндсэн мэдээлэл 4

Бүлэг 1. Иргэд газар олголтын талаар ойлголт муутай байна.

5

1.1 Тухайн жилийн газар зохион
байгуулалтын төлөвлөгөөг ГХБХБГ
боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулж
буй үйл ажиллагаа нь газрын талаарх хууль
тогтоомжийн дагуу явагдаж байна. 5

1.2 Дархан сумын газрын харилцаанд
Аймгийн Засаг дарга эрх хэмжээгээ
хэтрүүлжээ. 5

1.3 Газрын тухай хуулийн газар эзэмших
эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай
заалт газрын наймаа хийх эрсдэлийг
бүрдүүлж байна. 6

Бүлэг 2. Өмнөх аудитын мөрөөр Засаг дарга, ГХБХБГ-аас ямар нэгэн арга хэмжээ аваагүй, биелүүлээгүй байна.

14

Дүгнэлт 15

Зөвлөмж 16

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГХБГЗЗГ	Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ДУА	Дархан-Уул аймаг
ДУААГ	Дархан-Уул аймгийн Аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ААН	Аж ахуйн нэгж
ХАА	Хөдөө аж ахуй
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль
УГТСЭШХ	Ургамал газар тариалан судлалын эрдэм шинжилгээний хүрээлэн
ОУХТ	Олон Улсын Худалдааны төв
ГЗБТ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө

Аудит хийх үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатараас 2013 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 5/2823 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Дархан-Уул аймагт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрыг ашиглуулах, эзэмшүүлэх, өмчлүүлэх ажлыг хэрхэн зохион байгуулж байгаа болон Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн эсэхийг шалгаж дүнг холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Дархан-Уул аймгийн ИТХ-аас баталсан 2012, 2013 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газрын харилцаатай холбоотой гаргасан аймгийн Засаг даргын 2012 оны 11 сараас 2013 оны 6 дугаар сарын 15-ныг хүртэлх захирамж, ГХБХБГ, Хонгор сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг дарга нарын 2011, 2012 онд газрын харилцааны талаар гаргасан захирамжууд, Дархан, Хонгор сумдын иргэдээс УИХ-ийн гишүүн С.Ганбаатарт болон ажлын албанд ирүүлсэн санал, хүсэлтүүдийг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт болон түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмжийг ашиглан холбогдох албан тушаалтан, санал хүсэлт гаргасан иргэдтэй ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох баримт цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох журмууд, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгчийн гэрээний дэлгэрэнгүй бүртгэл зэргийг аудитын шалгуур үзүүлэлт болгов.

Үндсэн мэдээлэл:

Дархан-Уул аймаг Дархан, Орхон, Шарын гол, Хонгор гэсэн 4 сумтай, нийтдээ 327,5 мянган га нутаг дэвсгэртэй байна.

Аймгийн газар нутгийг 2012 оны Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар харуулбал:

/газрын хэмжээ га-аар/

Дэс дугаар	Аймаг, сумдын нэр	Нийт газар	Үүнээс					
			Хөдөө аж ахуйн газар	Хот тосгон бусад суурины газар	Зам, шугам сүлжээний газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Улсын тусгай хэрэгцээний газар
1	Дархан сум	9813	1745	6944	553	133	356	82
2	Хонгор сум	263957	178648	5702	3486	70685	4072	1364
3	Орхон сум	44180	38740	1243	1717	382	2080	16
4	Шарын гол	9553	4681	3808	127	786	151	1
	Нийт	327500	223814	17696	5883	71985	6658	1463

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь орон нутагт “Газрын тухай”, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай”, “Газрын төлбөрийн тухай” хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахын зэрэгцээ, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, газрын зөрчил маргааныг шийдвэрлэх зэрэг чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд “Монгол Улсад газар түүний хэвлий, ой, ус, амьтан болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” хэмээн газрын эрх зүйн үндсийг тодорхойлсон бөгөөд 2002 оны 6 дугаар сарын 7-нд “Газрын тухай”, 2002 оны 6 дугаар сарын 27-нд “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хууль УИХ-аар тус тус батлагдснаар иргэн, хуулийн этгээдэд шинээр газар олгох, өмчлүүлэх ажиллагаа сүүлийн жилүүдэд хүчтэй өрнөж байна.

Дархан-Уул аймагт 2013 оны 5 дугаар сарын байдлаар 19748 иргэн газар өмчилж авах өргөдөл, хүсэлт гаргаснаас Засаг даргын захирамжаар 9828 иргэнд 1117.95 га газрыг өмчлүүлжээ.

Аймгийн ИТХын Тэргүүлэгчдийн 2012 оны 8 дугаар сарын 30-ны 62 тоот тогтоолоор Монгол Улсын “Загвар хот” хөтөлбөрийн хүрээнд Дархан хотод баригдах 23-32 дугаар хорооллуудын хэсэгчилсэн төлөвлөгөөг баталжээ. Одоогоор дээрх хорооллуудын дэвсгэр зураг болон инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, инженерийн бэлтгэл ажлын зураг төсөл хийгдэж байна.

Бүлэг 1. Иргэд газар олголтын талаар ойлголт муутай байна.

1.1 Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газрын харилцаа, барилга хот байгууллалтын газар боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулж буй үйл ажиллагаа нь газрын тухай хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байна.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2003 онд боловсруулан хэрэгжүүлж, бүх сумдын гэр хорооллын зураглалыг аналогич хэлбэрээр хийж, газрын тооллогыг явуулж, бүртгэлийг шинэчилсэн бөгөөд 2007 онд Азийн хөгжлийн банкны тусламжаар хэрэгжсэн газрын бүртгэл, тооллого төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн хэмжээнд гэр хорооллын кадастрын зураглалыг бүрэн хийж мэдээллийн санд оруулжээ.

Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т зааснаар газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, хот байгуулалт, барилгын байршил, зориулалт, хэмжээ хил заагийг тогтоосон тухайн жилдээ хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг юм.

Аймгийн ИТХ, Засаг дарга Газрын тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлийг мөрдлөг болгон аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сум, аймгийн дүнгээр нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2011 оны 12 дугаар сарын 20-ны 100 дугаар тогтоолоор 2012 оны, 2013 оны 3 дугаар сарын 22-ны 23 дугаар тогтоолоор 2013 оны “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г тус тус батлуулсан байна.

Газрын харилцаа, газар олголттой холбоотой гарсан аймгийн ИТХ болон Засаг даргаас баталсан дүрэм, журам, тушаал, шийдвэр, ГХБХБГ-аас хэн гэдэг иргэнд хэдий хэмжээний газрыг ямар зориулалтаар олгосон, ямар аж ахуйн нэгж, иргэний газрыг хууль, журмын дагуу хураан авсан болон бусад шаардлагатай мэдээ, мэдээлэлийг хэвлэл мэдээлэл, радио, телевиз болон интернэт орчинг ашиглан иргэд, олон нийтэд сурталчилах, тайлбарлан таниулах ажлыг хангалттай зохион байгуулаагүйгээс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үл ойлголцох асуудал байнга гарч байгаа нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлах явцад тодорхойлогдож байна.

1.2 Дархан сумын газрын харилцаанд Аймгийн Засаг дарга эрх хэмжээгээ хэтрүүлжээ.

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалтад Аймгийн Засаг даргын бүрэн эрхэд “аймгийн ИТХ-аас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн сумын Засаг даргын саналыг авсан байна” гэж тодорхойлсон байна.

Гэтэл аймгийн төвийн газрын талаарх асуудлыг шийдвэрлэхдээ Дархан сумын Засаг даргын холбогдох санал авахгүйгээр аймгийн Засаг дарга шууд шийдвэрлэж байгаа нь дээрх хуулийн заалтыг зөрчсөн үйлдэл гаргаж байгаа бөгөөд мөн хуулийн 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтад туссан холбогдох эрх, үүргийг өөртөө авч, эрх хэмжээгээ хэтрүүлж байгаа нь Дархан сумын Засаг даргын газрын тухай хуульд заасан газрын харилцааны талаарх бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг хязгаарласан байна.

1.3 Газрын тухай хуулийн газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай заалт газрын худалдаа явуулах эрсдлийг бүрдүүлж байна.

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлд Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хоорондоо газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр шилжүүлэх, барьцаалж болохыг заасны дагуу газрын эрхийн гэрчилгээг иргэд хоорондоо аймгийн ГХБХБГ-аас лавлагаа авахгүйгээр гэрээ хийж, нотариатаар батлуулан шилжүүлж байгаа нь газар эзэмших эрхээ худалдан борлуулах эрсдлийг бүрдүүлж байна. Түүнчлэн Газрын тухай хуульд нэг иргэн гэр бүлийн хэрэгцээндээ хуульд заасан хэмжээгээр хэдэн удаа эзэмшиж болох эсэх талаар тодорхой тусгаагүй, энэ талаар газрын албанаас хяналт тавих ямар нэг зохицуулалт, механизм байхгүй байна.

Дээрх үйл ажиллагаанд хяналт тавих, бүртгэл судалгаанд хамруулах, зохицуулалт хийх ажлыг аймгийн ГХБХБГ-аас хангалттай хэмжээнд зохион байгуулж ажиллаагүй байна.

2012 онд Дархан-Уул аймгийн Аудитын газар “Газар олголт, ашиглалттай холбоотой харилцааны зохион байгуулалт, үр дүн” сэдэвт аудитаар аймгийн Засаг дарга болон ГХБХБГ инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой газруудыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад төсөл сонгон шалгаруулалтгүйгээр олгосон ба газраа зориулалтын дагуу ашиглаагүй, газрын төлбөрөө төлөөгүй байхад эрхийн гэрчилгээг сунгасан, бусдад шилжүүлсэн зэрэг зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

Иргэн Д.Эрдэнэсайхан Аймгийн Засаг даргын 2012 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 309 тоот захирамжаар Анагаах ухааны коллежийн оюутны байрны зүүн талд үйлчилгээ, орон сууц, агуулах барих зориулалтаар 6000 м² газар авсан. Энэхүү шийдвэрийг үндэслэн 2012 оны 7 дугаар 18-ны өдөр 2 жилийн хугацаатайгаар эзэмшихээр ГХБХБ-ын газрын газар зохион байгуулагч, инженер Ю.Ариунболдтой гэрээ байгуулсан боловч 3 сарын дараа буюу 2012 оны 10 сарын 24-ны өдрийн 487 тоот захирамжаар иргэн Б.Баянжаргалд эзэмших эрхийн гэрчилгээ шилжсэн байна.

Иргэн Ц.Гэрэлмаад аймгийн Засаг даргын 2012 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн 194 тоот захирамжаар Техникийн коллежийн оюутны байрны урд нийтийн орон сууцны зориулалтаар 15061 м² газар олгожээ. Ц.Гэрэлмаа анх үйлчилгээний зориулалтаар 3000 м² газар хүссэн өргөдөл гаргасан байна. Дээрх шийдвэрийг үндэслэн ГХБХБ-ын газрын газар зохион байгуулагч А.Нармандах 2 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх тухай гэрээ хийсэн боловч 5 сарын дараа “Минж проперт” ХХК-нд аймгийн Засаг даргын 2012 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 487 тоот захирамжаар газар эзэмших эрхээ шилжүүлсэн байна.

Түүнчлэн аймгийн Засаг даргын 2011 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 148 тоот захирамжаар иргэн Н.Мэндзоригт Дархан сумын 14 дүгээр багийн 3-р хороололд 800 м² газрыг 2 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх эрх өгч, газар зохион байгуулагч Ю.Ариунболдтой гэрээ хийсэн бөгөөд уг газрыг иргэн Н.Мэндзоригт 2012 оны 7 дугаар сарын 20-ны өдөр иргэн Н.Пүрэвдашд 55,0 сая төгрөгөөр худалдан 2012 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 363 тоот захирамжаар газар эзэмших эрхээ шилжүүлсэн байгаа нь иргэд олон байршилд их хэмжээний газрыг эзэмших эрхийн гэрчилгээгээр авч бусдад худалдаж байгаа үйлдэл гаргасан байна.

Аймгийн Аудитын газраас 2012 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар Газрын тухай хуулийг зөрчсөн нэр бүхий 54 иргэн, ААН-ийн нэгжийн талбарын эрхийг хүчингүй болгуулах тухай албан шаардлагыг биелүүлээгүй, аудитаар зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээг аймгийн Засаг дарга, ГХБХБГ-ын

холбогдох албан тушаалтнууд авч хэрэгжүүлээгүй, зөрчил дутагдал давтагдсан хэвээр байна.

Дархан сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын харилцааны талаар аймгийн Засаг даргын гаргасан захирамжуудыг 2012 оны 11, 12 сар, 2013 оны эхний 5 сарын байдлаар үзүүлбэл:

Үзүүлэлт	2012 оны 11, 12 сар			2013 оны 1-6 сарын 15 хүртэлх		
	Захирамж/ тоо /	Иргэн	ААН	Захирамж /тоо /	Иргэн	ААН
1. Газар эзэмшүүлэх						
Нийт олгосон / тоо /	22	326	47	10	61	8
Үүнээс: ГЗБТ-д тусгагдаагүй газарт		266	40		43	7
Газрын хэмжээ бүгд / га/		36.4	74,8		6,4	12,8
Үүнээс:ГЗБТ-д тусгагдаагүй газарт		28.8	66		5,4	11,8
2. Газар эзэмших эрхээ бусдад шилжүүлсэн						
Тоо	4	68	8	4	76	8
Талбайн хэмжээ / га /		2,5	1,6		3,4	10,3
3. Эзэмших эрхийг сунгасан						
Тоо	5	36	15	7	76	16
Талбайн хэмжээ / га /		6,3	2,5		14,0	13,1
4. Эзэмших эрхийг хүчингүй болгосон						
Тоо	2	2	1	5	179	2
Талбайн хэмжээ / га /		0.9	0.1		12.5	10.0

Дээрх хүснэгтээс харахад газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт аймгийн Засаг дарга 2012 оны 11 дүгээр сараас 2013 оны 6 дугаар сар хүртлэх хугацаанд 31 удаа захирамж гаргаж нэр бүхий 309 иргэн, 47 аж ахуйн нэгжид нийтдээ 112 га газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан нь аймгийн ИТХ-ын 2011 оны 100, 2013 оны 23 дугаар тогтоолын холбогдох заалтыг зөрчсөн байна. /Хавсралт 1/

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2012 оны байдлаар газрын асуудлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлт, түүнийг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Сумын нэр	Ирүүлсэн хүсэлт	Шийдвэрлэсэн	Шийдвэрлэлтийн хувь
1	Дархан	5424	3797	65,0
2	Хонгор	717	588	82,0
3	Орхон	546	259	47,4
4	Шарын гол	270	209	77,4
5	Дүн			

Жич: Дархан сумын хэмжээнд шийдвэрлэгдээгүй байгаа 35 хувь нь иргэн өргөдөл, хүсэлтээ ГХБХБГ-т гаргаж бүртгүүлээд, шийдвэрлэгдээгүй байгаа байгаа иргэдийн тоо багтав.

УИХ-ийн гишүүн С.Ганбаатарт Дархан-уул аймгийн иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн өргөдөл, санал хүсэлтийг шалгахад дараах байдалтай байна. /Холбогдох баримт материалыг хавсаргав./

1. Иргэн С.Зоригтбаатар: Дархан сумын 14 дүгээр баг 2 дугаар хороололд амины орон сууцууд бариад байна. Инженерийн шугам сүлжээтэй газар нийтийн орон сууц түлхүү барих шаардлагатай байгаа тухай хүсэлт.

Бодит байдал: Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд амины орон сууцны хороолол байгуулахаар төлөвлөсөн байна. Дээрх 2 дугаар хороололд Сигма ХХК-ийн 72 айлаас 36 айл, Минж проперти ХХК-ийн 236 айлаас 63 айл, ОССК-ийн 50 айлаас 25 айл, Иргэн Алтанцэцэгийн 25 айл, Дархан нэхий ХХК-ийн 100 айлаас 25 айлын нийтийн орон сууцны барилга баригдаж дуусч байна. Цаашид 2 дугаар хороололд 2,3 тэрбум төгрөгөөр цахилгааны эх үүсвэр шийдэгдсэнээр нийтийн орон сууц барих ажил үргэлжлэхээр төлөвлөсөн байна.

2. Иргэн О.Эрдэнэчулуун /Наран толгойн хэсэг иргэдийг төлөөлж/: Нарантолгойн зүүн талд 7 дугаар гудамжны урд 11 айлд газар өгдөггүй. Худгийн баруун талд Бэгзээ гэх иргэний 2 айлын газар байдаг. Микрийн Санчир дэлгүүрийн хажууд 2-3 айлын газар зарна гэсэн.

Бодит байдал:

/Зураг-1, Нарантолгойн арын зөвшөөрөлгүй буусан айлууд/

/Зураг-2, Иргэн Бэгзийн гэх 2 айлын хашаа/



/Зураг-1/ Тус айлууд хот зохион байгуулалтын төлөвлөлтөнд ороогүй, телевиз, радиогийн дахин дамжуулах станцад ойрхон буусан нь Харилцаа холбооны тухай хуулийн 28 зүйлийн 28.1.3-т заасан “Хамгаалалтын зурвас газар гэж Радио релейны шугамын станц хоорондын буюу сансрын холбооны хиймэл дагуулын газрын нэвтрүүлэх станцын долгион цацалтын орон зай, тухайн станцаас тал бүрт 300 метр голчтой байна” заалтыг зөрчиж байгаа тул 2012 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Дархан сумын 8 дугаар баг Нарантолгойн 7 дугаар гудамжны ард буусан нэр бүхий иргэдэд ГХБХБГ-аас мэдэгдэх хуудас хүргэж тогтоосон хугацаанд шаардлага биелүүлээгүй иргэдийг Дархан-Уул аймгийн Засаг даргын 277 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2012 оны 5 дугаар сарын 8-ны өдөр газрыг албадан чөлөөлсөн байна.

/Зураг-2/ Иргэн Бэгзийн гэх 2 том хашааны газраар аймгийн авто замын трас тавигдахаар төлөвлөгдсөн тул ГХБХБГ-аас уг газрыг чөлөөлөх мэдэгдэл хүргүүлж, өөр газарт зөвшөөрөл өгсөн боловч тухайн иргэн хашаагаа буулгаагүй, МУ-ын хууль тогтоомжийг биелүүлээгүй байна.

3.1. 15 дугаар багийн хэсэг иргэд: 15 дугаар багийн нутаг дэвсгэр, ШУТИС-ийн урд талын газрыг өмнөх жилүүдэд иргэдэд өгөхгүй, нөөцөд байгаа гэж байсан боловч, одоо хувийн орон сууцны хороолол боллоо. Инженерийн шугам сүлжээтэй газар нийтийн орон сууц бариулж болдоггүй юм уу? Мөн

3.2. С.Батбаяр /9 дүгээр баг/: А зэрэглэл ШУТИС-ийн урд байшин хороолол ямар эрх зүйн үндэслэлээр олгосныг шалгуулах хүсэлтэй байна.

Бодит байдал: Дархан сумын 15 дугаар баг, 10 дугаар хороололд ШУТИС-ийн урд амины орон сууцны зориулалтаар хот байгуулалтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газарт газар олголт хийгдэж иргэд газрыг зориулалтын дагуу ашиглаж байна. Тус хороололд нийтийн орон сууц барих зориулалтаар “Альфаконстракшн” ХХК 564 айлын орон сууц барихаас 63 айл баригдаж байна. Иргэн Батсайхан, Ш.Отгонбаатар нар 47 айлын орон сууц, Номин холдинг ХХК нийтийн орон сууц барихаар холбогдох зөвшөөрлөө авч зураг төсөл боловсруулах ажлыг хийж байна.

/Зураг-3/



/Зураг-4/



Дархан сумын 15 дугаар баг, 10 дугаар хороолол, ШУТИС-ийн урд талын газар

1990 оноос 2012 он хүртэл тухайн үеийн Засаг даргын шийдвэрээр Цахилгаан дамжуулах сүлжээний 10 айл, Төмөрлөгийн үйлдвэрийн 10, бусад иргэд гэх мэт 101 айлд 19,4 га газрыг амины орон сууцны зориулалтаар өмчлүүлж, эзэмшүүлсэн байна.

5. Иргэн С.Гансүх /Дархан сумын 9 дүгээр баг/: Морин хуурын цогцолборын доорх цэнхэр хашаатай зочид буудлын зориулалттай баригдаж буй гэх газрыг хүүхдийн цэцэрлэг, ахмадын эмнэлэг болгож болохгүй юу?


Бодит байдал: Дархан Өүлэн ХХК Дархан-Уул аймгийн Засаг даргын 2010 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 429 дугаар захирамжаар үйлчилгээ, зочид буудлын зориулалтаар 7000 кв.м газрыг гэрээний дагуу эзэмшсэн байна. Уг компани барилгын зураг, төслийг боловсруулж, батлагдсан зураг төсөл, газар эзэмших гэрээний дагуу барилга угсралтын ажлыг 2012 оноос эхлэн гүйцэтгэж, тодорхой ажлуудыг хийж байгаа нь хууль зөрчөөгүй тул түүнийг зогсоох үндэслэл байхгүй байна.

6. Ё.Энэбиш: Газраа өмчилж авах гээд өргөдөл гаргаад 2 сар болж байгаа боловч шийдэж өгөөгүй.

Бодит байдал: Иргэн Ё.Энэбиш 2013 оны 5 дугаар сарын 14-ны өдрийн 13 цаг 52 минутанд ГХБХБГ-т шинээр газар өмчилж авахаар өргөдөл өгсөн бөгөөд өргөдөл 13377 дугаарт бүртгэгдэж, иргэн газар авах хуудас /өргөдөл хүлээж авсан тухай тодорхойлолт/-аа авч, өмчлөлийн газар авах эрхээ нээлгүүлсэн байна.

ГХБХБГ-аас 2013 оны аймгийн ИТХ-ын 22 дугаар тогтоолын дагуу Дархан сумын Малчин баг Хөтөл хороололд 7 хоног бүрийн 5 дахь өдөр буюу баасан гаригийн 10 цагт 60 иргэнд газар олгох үйл ажиллагаа болдог байна. Тухайн иргэн газар авах хуудас /өргөдөл хүлээж авсан тухай тодорхойлолт/-аа авч очоод газраа авах боломж нээлттэй байна. Иргэн Ё.Энэбишийн 94121679 дугаарын гар утсаар дуудан уулзаж, лавлахад газраа сонгох тухай ойлгоогүй, энэ талаар очиж тодруулаагүй, өргөдлийн хариуг хүлээсэн байдалтай байв.

Аймгийн ГХБХБГ газар эзэмших, өмчлөх, ашиглах өргөдөл, хүсэлтийг Landmanager программыг ашиглан бүртгэж, гэрээ, гэрчилгээ олгож байгаа хэдий ч иргэдэд мэдээ мэдээллийг түгээх, зааварчилгаа өгөх, харилцах үйлчилгээ хангалтгүй байгааг харуулж байна.



7. П.Баясгалан: 2000 онд 2 дугаар хороололд газар авсан. Нүүлгэн шилжүүлж Дархан зочид буудлын зүүн талд газар олгоно гээд олгохгүй байна.

Бодит байдал: Дархан-Уул аймгийн Засаг даргын 2001 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 305 дугаар захирамжаар Дархан сумын 14 дүгээр баг, 2 дугаар хороололд амины орон сууцны зориулалтаар нийт 106 иргэдэд 500 м/кв газар олгож инженерийн шугам сүлжээний зардал 2,5 сая төгрөг төлүүлж газар олгохоор шийдвэрлэжээ.

2002 онд Азийн хөгжлийн банкны зээл, төслийн шугамаар бохир, дулаан, цахилгааны шугам сүлжээг иж бүрнээр хийж төслийн зүгээс гарсан зардлын 70 хувийг бүрэн хариуцаж 30 хувийн төлбөр болох 2,5 сая төгрөгийг иргэд хариуцахаар шийдвэрлэсэн боловч газар авсан зарим иргэд 2,5 сая төгрөгийг төлж барагдуулаагүйгээс газрыг буцаан хураан авч дахин хуваарилалт хийсэн байна.

Дархан зочид буудлын баруун, зүүн талд шинэчлэн боловсруулж батлуулсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр амины орон сууц, нийтийн орон сууц барихаар төлөвлөж гадна инженерийн шугам сүлжээг өөрсдийн хөрөнгөөр хийх болзолтойгоор газар олголт хийгдсэн байна. Цаашид тухайн газрын ойролцоо газруудад аймгийн ГХБХБГ-аас дахин төлөвлөлт хийж хууль журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхой болзол нөхцөлтэйгөөр газар олгох боломжтой байна.

7. С.Ууганбаяр: Дархан зочид буудлын хойд тал, Оюуны ирээдүй сургуулийн зүүн хойд талын газрууд, СОС төвийн ойролцоох газруудад газар авахаар хөөцөлдөөд чадаагүй.

Бодит байдал: Дархан зочид буудлын хойд талд 15 дугаар баг 13 дугаар хороололд улсын төсвийн 2,8 тэрбум төгрөгөөр цахилгаан, дулаан, бохир цэвэр усны дэд бүтэц баригдсан газарт 100 айлд хувийн орон сууцны газар олгохоор төлөвлөгдсөн байна. Одоогийн байдлаар газрыг иргэн, аж ахуйн нэгжид нэр зааж олгоогүй бөгөөд аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсээс 100 айлын хувийн орон сууц барих журмыг баталж гаргахаар төлөвлөсөн байна.

Батлагдсан журмын дагуу иргэн С.Ууганбаяр хувийн орон сууц барих хүсэлтээ холбогдох байгууллагад гаргаж газар эзэмших боломжтой байна.

8. Чулуун-Эрдэнэ: 17 дугаар сургуулийн хойно граж барих өргөдөл өгөөд 2 жил болж байна. Хариу өгөөгүй. Энэ хавийн газрыг болон УГТСЭШХ хүртэлх газрыг ямар эрх зүйн үндэслэлээр олгосныг шалгуулмаар байна.

Бодит байдал: Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр бүсэд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2009 оноос хойш аймгийн Засаг дарга автограж, авто угаалга, авто үйлчилгээний зориулалтаар газар олгохыг хориглосон шийдвэр жил тутам гаргаж, хэрэгжүүлж ирсэн байна. Иймд иргэн Чулуун-Эрдэнийн 17 дугаар сургуулийн ард гражийн газар авах хүсэлтийг шийдвэрлээгүй байна.

Харин 17 дугаар сургуулиас Хүрээлэн хүртэл жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх 95 га газарт, орон сууц хорооллын 11, 13, 14, 24, 25 дугаар хорооллуудыг төлөвлөж ОУХТөв, Хүрээлэнгийн хооронд хүүхдийн цэцэрлэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв, сургууль, нийтийн орон сууц, худалдаа аж үйлдвэрийн танхимийн зориулалтын байр, жижиг дунд үйлдвэр барих зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон байна.

9. Дэлгэрсүрэн /7 дугаар баг/: Майхантын 4-47 тоот хашаанд ах Шарбанди сүүлийн 15 жил амьдарч байна. Уг хашааг хууль бусаар өөр хүний нэр дээр шилжүүлж гэрчилгээ олгосон. Холбогдох бичиг баримтыг нь Газрын алба үзүүлдэггүй.

Бодит байдал: Иргэн Т.Бадарч тус багийн Майхантын 4-47 тоот газар дээрээ 1976 оноос хойш амьдарч байсан нь үнэн гэсэн 7 дугаар багийн Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн аймгийн Засаг даргын 2008.01.08-ны өдрийн 06 дугаар захирамжаар өөрийн амьдарч байгаа газраа өмчилж авсан байна.

Анх 2003 онд газар өмчлөлийн ажил эхлэх үед хийгдсэн гар зурагт Т.Бадарч нь 663 м/кв талбай бүхий газар эзэмшиж байгаад 2008 оны 1 сарын 8-ны өдөр өмчилж авсан нь хэмжилтийн материалаас харагдаж байна.

10. 10 дугаар баг, 1а, 1б байрны оршин суугчид: Гаднах хүүхдийн тоглоомын талбайд барилга барьж байгааг зогсоох шаардлагатай байна.

Бодит байдал: Иргэн Э.Мөнхсоёлд 2011 онд 900 м/кв газрыг аймгийн Засаг даргын захирамжаар олгосон бөгөөд 2012 онд иргэн Г.Одбаярт газар эзэмших эрхээ шилжүүлсэн байна.

Анх олгосон газрын хэмжээ өөрчлөгдөөгүй бөгөөд тухайн байрны иргэдийн гомдлын дагуу шалгахад барилгын суурь ухах үед барьсан түр хашаа нь тоглоомын талбай шахсан байгаа нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэх боломжгүй байна.

11. Д.Даваадолгор /8 дугаар баг/: Микрийн зүүн хажуу дэнж дээр 2 том хашаа барьж айл буусан.

Бодит байдал: Дархан сумын 8 дугаар баг Нарантолгойд Дархан-Уул аймгийн Засаг даргын 2012 оны 11 дүгээр сарын 5-ны 506 дугаар захирамжаар нэр бүхий 5 иргэний газрын зөвшөөрлийг олгож 2013 оны 5 дугаар сарын 27-ны өдөр газар эзэмших гэрээ байгуулсан байна.

Дээрх иргэний мэдээллийн дагуу шалгаж үзэхэд замын хажууд байгаа модон /дотроо блокоор граж барьсан / том хашааг зөвшөөрөлгүй барьсан бөгөөд 2013 оны

5 дугаар сарын 23-ны өдөр “газар чөлөөлөх тухай” мэдэгдэлийг ГХБХБГ-аас хүргүүлж дурьдсан хугацаанд газрыг чөлөөлөхгүй бол албадан чөлөөлөх арга хэмжээ авах болохыг дурьдсан байна.

12. Д.Энхцэцэг /8 дугаар баг/: Төвийн инженерийн шугам сүлжээтэй газар 75 хүүхдийн цэцэрлэг барилга барих газар хүссэн өргөдөл өгсөн.

Бодит байдал: Аймгийн ИТХ-аас 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд инженерийн шугам сүлжээтэй газарт хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар 2 газар дуудлага худалдаагаар олгохоор шийдвэрлэсний дагуу 2013 оны 5 дугаар сарын 19-нд дуудлага худалдааг зохион байгуулж 1 цэцэрлэгийн газрыг олгосон байна.

Үлдсэн 1 нэгж талбайн газрын дуудлага худалдаанд оролцох боломж иргэн Д.Энхцэцэгт байгаа бөгөөд цаашид инженерийн шугам сүлжээнд холбогдох нөхцөлтэй гэр хороололд олгож байгаа газарт 10-14 цэцэрлэг барихаар тул дээрх газарт барилга барих хүсэлт гаргавал шуурхай шийдвэрлэх боломж ГХБХБГ байна.

13. П.Баярцэнгэл хэсэг нөхөд: Хүүхдийн цэцэрлэгийн барилга барих газар хүссэн өргөдөл өгсөн.

Бодит байдал: Иргэн П.Баярцэнгэлийн эхнэр Д.Тунгалагийн нэр дээр Дархан-Уул аймгийн Засаг даргын 2013 оны 183 дугаар захирамжаар Дархан сумын 15 дугаар баг 7 хороололд 1200 м/кв газрыг хүүхдийн цэцэрлэг барих зориулалтаар 2 жилийн хугацаатайгаар олгож гаргасан хүсэлтийг нь шийдвэрлэсэн байна.

14. Иргэдээс УИХ-ын гишүүнтэй уулзахдаа: Тэс петролиум ХХК-д төмөр замын дагуу газар олгосон ямар үндэслэлтэй вэ? Шалгуулж өгөөч.

Бодит байдал: Тэс петролиум ХХК-ны хүсэлтийг үндэслэн Дархан-Уул аймгийн Засаг даргын 2011 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн 204 дүгээр захирамжаар Тэс петролиум ХХК-нд Дархан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэр төмөр замын дагуу 2 жилийн хугацаатайгаар газар олгосон байна.

Энэ нь Төмөр замын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 20.7-д “Төмөр замын байгууллага нь төмөр замын зурвас газарт хамаарах сул, чөлөөтэй газрыг газар тариалан, зорчигч үйлчилгээ, шатамхай болон аюултай ачаанаас бусад ачааг хадгалах, буулгах, үйлчилгээг эрхлэх болон бусад зориулалтаар төмөр замын тээврийн аюулгүй байдлын шаардлагад чанд нийцүүлэн иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэн ашиглуулж болно.” Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 27.10-д “Төмөр замын зурвас газраас гаднах аюулгүйн бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах, аливаа үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга аюулгүйн байдлын талаар гаргасан зөвлөмж, дүгнэлтийг харгалзан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн олгоно.” гэж заасныг зөрчсөн байна.



/Зураг 5: Төмөр зөм болон авто замын дунд барьсан шатхуун түгээх станц/

Хонгор сумын иргэдээс гаргасан өргөдөл хүсэлтийг шалгаж үзэхэд:

- Хонгор сумын хэсэг иргэд /Иргэн Ц.Мөнхтогос, Ц.Цэрэндолгор, Г.Цэцэгмаа, А.Тунгалаг, Г.Оюунцэцэг, Х.Баярмагнай / 2013 оны 6 дугаар сарын 6-ны өдөр “Шилжүүлэн эзэмшүүлэх нэрээр гадны иргэдэд газрыг зарж байгаа учир багийн ИНХ-аар оруулж сумын иргэдэд олгуулж өгнө үү.” гэсэн өргөдөл,
- ИТХ-ын төлөөлөгч Б.Оюунцэцэг 2013 оны 5 дугаар сарын 9-нд гаргасан “Гадны иргэдэд газар олгоод байна. Мөн газрын асуудлыг Засаг дарга ганцаараа шийдэж байгааг зогсооё” гэсэн санал,
- Иргэн Ц.Энхбаатар 2013 оны 5 дугаар сарын 9-ны “Газрын өргөдөл өгөөд одоо болтол шийдэж өгөөгүй учир ИТХ-аар хэлэлцүүлж, иргэдэд газар олгох хүсэлтэй байна” гэсэн өргөдөл,
- Иргэн С.Нацагдорж 2013 оны 5 дугаар сарын 9-ны “Сумын газар тариалан эрхлэх хүсэлтэй иргэдэд газар олдохгүй, гадны иргэдэд ихээр олгож байна. Газрын асуудлыг ИНХ-аар хэлэлцүүлж олгохыг хүсэж байна” гэсэн өргөдөл, санал хүсэлтийн дагуу сумын ЗДТГ, ИТХ-ын хамтарсан ажлын хэсэг Зулзага голын дагуу төмс хүнсний ногооны зориулалтаар газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжүүдийн газар ашиглалтын байдалд хяналт шалгалт, хэмжилтийг хийж газар дээр нь очиж ажилласан байна.

Шалгалтаар нийт 38 иргэн, аж ахуйн нэгжийн газарт 221,04 га талбайд хэмжилт хийж, үүнээс 58 га газарт зөвшөөрөлгүй нэмж хагалсан байсныг тогтоосон бөгөөд ажлын хэсэг хуралдаж ИТХ-аар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2013 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн сумын ИТХ-ын 33 дугаар тогтоолоор нэр бүхий иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийг цуцалсан тул аудитын явцад иргэдийн гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэгдсэн гэж үзлээ.

Сумын удирдлага газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр гаргасан дүрэм, журам, заавар, зөвлөгөөг иргэд олон нийтэд нээлттэй хүргэдэггүй тул иргэд ямар нэг мэдээлэлгүй байгаагаас өргөдөл гомдлыг байнга гаргаж байгаа нь аудитын шалгалтын явцад тогтоогдлоо.

Иргэдийн өргөдөл, хүсэлтийг харгалзан Хонгор сумын удирдлага сумын 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт тодотгол оруулсны дараа эргэн хуваарилалт хийх шийдвэрлэх боломжтой байна.

Бүлэг 2. Өмнөх аудитын мөрөөр Засаг дарга, ГХБХБГ-аас ямар нэгэн арга хэмжээ аваагүй, биелүүлээгүй байна.

2012 онд Дархан-Уул аймгийн Аудитын газар “Газар олголт, ашиглалттай холбоотой харилцааны зохион байгуулалт, үр дүн” сэдэвт аудитыг Дархан сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд, аймгийн Засаг дарга, ГХБХБГ-ын 2011, 2012 оны 10 дугаар сарыг дуусталх газрын харилцааны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлийн аудит хийж илэрсэн зөрчил дутагдалыг засах талаар аймгийн Засаг дарга Г.Эрдэнэбат, ГХБХБГ-ын дарга З.Мөнхбат нарт иргэн, аж ахуйн нэгжүүдэд газар олгох, эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах харилцаатай холбоотой асуудлаар 4 зөвлөмж, 2 албан шаардлага өгч газар эзэмших эрхийн зөрчилтэй 54 иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ, гэрчилгээг хүчингүй болгох, газрын төлбөрөө гэрээний дагуу төлөөгүй зөрчилд холбогдох арга хэмжээ авах талаар албан шаардлага хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл ямар нэг арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аймгийн ГХБХБГ 6 дугаар сарын 20-нд 573 тоот албан бичгээр гүйцэтгэлийн аудитын зөвлөмжтэй холбоотой асуудлаар ажлын тайлан, тайлбарыг ирүүлсэн хэдий ч албан шаардлагад тусгагдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн газрын зөрчлийг аймгийн Засаг даргын захирамжаар хүчингүй болгох асуудалд аймгийн Засаг дарга, ГХБХБГ-аас холбогдох зохион байгуулалтын болон бусад шаардлагатай арга хэмжээ аваагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнтэй холбогдуулан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ГХБХБГ боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж буй нь газрын талаарх хууль тогтоомжийн дагуу явагдаж ирсэн хэдий ч газар олголтын үйл ажиллагаанд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг олгосон, аймгийн Засаг дарга эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан зэрэг хууль журам зөрчсөн, эрсдэлтэй гэж үзэж болох зөрчил дутагдал гаргасан байна.
2. Тус аймагт газар олголт, өмчлүүлэлт, эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, сунгах, хүчингүй болгох, ашиглуулахтай холбоотой асуудлыг Дархан сумын хувьд аймгийн Засаг даргын гаргасан захирамжаар шийдвэрлэж байгаа нь газрын тухай хуулийн 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтад туссан сумын Засаг даргын холбогдох эрх, үүргийг аймгийн Засаг дарга, ГХБХБГ өөртөө авч эрх хэмжээгээ хэтрүүлж байгааг харуулж байна.
3. ГХБХБГ газрын харилцааны талаар олон нийтэд өгч буй мэдээлэл ойлгомжгүй, ил тод биш, иргэний гаргасан өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн хариуг хуулийн хугацаанд албан ёсоор өгдөггүй, хүнд суртал гаргадаг зэрэг нь иргэдэд буруу ойлголт төрүүлэх, бухимдуулах үндэслэл болж байна.
4. Аймгийн Засаг дарга болон ГХБХБГ-аас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулахдаа ИТХ-аас баталсан хот зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг мөрдөж ажилллаагүйгээс газар олголт эмх замбараагүй болж зүй бус ашиглалт, газрын маргаан үүсэх бусад зөрчил гарах үндэслэл болж байна.
5. Дархан-Уул аймгийн Аудитын газрын 2012 оны “Газар олголт, ашиглалттай холбоотой харилцааны зохион байгуулалт, үр дүн” аудитын дүнг үндэслэж өгсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр Засаг дарга, ГХБХБГ-аас ямар нэгэн арга хэмжээ аваагүй, биелүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга С.Насанбатад:

1. Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3-т заасны дагуу ИТХ-аас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудаас бусад газрыг сумын ИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх ашиглуулах тухай сумын Засаг даргын газрын харилцааны талаарх бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
2. ИТХ-аас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсанаас өөр газарт газар олголт хийсэн шийдвэрүүдийг хүчингүй болгох, хойшид давтан гаргуулахгүй байх арга хэмжээ авах;
3. Өмчлөгдснөөс бусад газрыг бусдад зарах, энэ талаар хэвлэл мэдээллээр явж буй зар мэдээнд тавих хяналтыг сайжруулж, таслан зогсоох арга хэмжээ авах.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Ж.Мөнх-Эрдэнэ болон сумдын ИТХ, Засаг дарга нарт:

1. Газрын харилцааны талаар иргэн, аж ахуйн нэгжид өгөх мэдээллийг ил тод, ойлгомжтой байлгах арга хэмжээ авах. Үүнд:
 - Тухайн жилд шинээр олгохоор ИТХ-аас баталсан газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүнд тусгагдсан газрын байршил зэргийг ил тод болгож мэдээлэх;
 - Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас газартай холбоотой гаргах өргөдөл, хүсэлт болон бүрдүүлэх баримт материалыг холбогдох хууль, журам, зааварт хэрхэн тодорхойлсныг ойлгомжтойгоор загвар байдлаар гаргаж олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, бусад боломжит байдлаар сурталчлах, таниулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;
 - Үйлчлүүлэгчийн өгч буй өргөдөл, хүсэлт, гомдлыг хүлээн авахдаа бүртгэл хөтлөлт хийж байх, гаргасан шийдвэрийн хариуг албан тоотоор хүргүүлэх ажлыг хэвшүүлж энэ ажилд хариуцлагагүй хандсан албан тушаалтанд тухай бүрт нь арга хэмжээ авч нийтэд мэдээллэдэг тогтолцоог бий болгох;
 - Иргэн, аж ахуйн нэгжүүдийн гаргасан шийдвэрлэгдээгүй өргөдөл, хүсэлтийн талаарх мэдээллийг нээлттэй авах боломжийг бүрдүүлэх.
2. Үйлчилгээний чанар, хүртээмж, харилцааны соёлд анхаарч ажиллах, дотоод хяналтын механизмыг бүрдүүлэх,
3. Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг давтан гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч зөвлөмжийн биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 10-ны дотор багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэх.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Дархан-Уул аймаг дахь газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын байдал, хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг УИХ-ын гишүүн С.Ганбаатар, Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбатад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг хангаж дүнг 2013 оны 12 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Ж.Мөнх-Эрдэнэд зөвлөсүгэй.
4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Нийцлийн аудитын газар (Б.Алтанзул)-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070527

tushaal-2013